

**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин Буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
<p align="center">ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.</p> <p align="center">/“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/ ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛНЭ.</p>								
1.1	Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх.	-	Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100		Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4155 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2894 бүртгэлийн 4865 нотлох баримтыг цахимжуулж, хянан мэдээллийн санд баталгаажуулсан байна.	100
1.2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх.	-	Иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100		Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь иргэн хуулийн этгээдээс 2493 мэдүүлэг хүлээн авч холбогдох бүртгэлийг хийлээ. Нийт бүртгэлийн 284-г анхны бүртгэл, 308-г өмчлөх эрхийн бүртгэл, 1723-г барьцааны гэрээний бүртгэл, 178-г бусад бүртгэл тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 173, газар өмчлөлийн 110 хувийн хэрэг шинээр нээж 2209 хувийн хэрэгт баяжилт үйлчилгээ хийлээ.	100

1.3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх.	-	Иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100	Хуулийн этгээд, эд хөрөнгий эрхийн улсын бүртгэлийн тасаг нь шинээр 75 хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэж хуулийн этгээдийн 174 мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгэж	100
1.4	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо	24142	26000	Тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлэх, Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг хэрэгжүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын ил тод байдлыг хангах зорилготой ХУУЛЬЧДЫН ПРО БОНО БУЮУ "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"- өөр цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан 6 иргэнд тоон гарын үсэг олгон ажилласан байна. Аймгийн хэмжээнд насанд хүрсэн нийт 49754 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2024 оны тайлант хугацаанд 24142 иргэнд, 2025 оны тайлант хугацаанд 2225 иргэнд өссөн дүнгээр 26367 иргэнд, 2026 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 28429 иргэнд тоон гарын үсэг олгож ажилласан байна.	100

1.5	Иргэний улсын бүртгэлийн архивын баримтыг тоолох цахимд ороогүй баримтуудыг цахимжуулах.	-	Цахимжуулсан баримтын тоо.	-	73000	Иргэний улсын бүртгэлийн архивын тооллогыг хэлтсийн даргын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/28 дугаар тушаалаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг томилогдон тооллогыг зохион байгуулж 55310 хувийн хэргийн 218262 маягыг тоолж гадна хайрцгийг сольж тоо бүртгэл хөтлөн тооллогын явц 98,5 хувьтай үргэлжлэн ажиллаж байна.	100
1.6	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл лавлагаа өгөх.	-	Ирүүлсэн хүсэлтийн биелэлтийн хувь	100	100	Улсын бүртгэлийн Дэт киоск машинаас иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн чиглэлээр цахим үнэмлэхийн лавлагаа 1805, байнга оршин суугаа хаягийн лавлагаа 111, гэрлэлтийн лавлагаа 67, гэрлэсний бүртгэлгүй лавлагаа 8, регистрийн дугаар өөрчилсний бүртгэлийн лавлагаа 1, төрөлтийн лавлагаа 22, хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй эсэх лавлагаа 2, хуулийн этгээдийн хаягийн лавлагаа 1, эд хөрөнгийн лавлагаа 108, эд хөрөнгөтэй эсэх лавлагаа 7 нийт 2133 лавлагааг цахимаар, Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд улсын бүртгэгчээс 1261, хууль хяналтын байгууллагад 380, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 56, хууль хяналтын байгууллагад 19 лавлагааг тус тус олгосон. Нийт 3849 лавлагааг иргэн аж ахуй нэгж хууль хяналтын байгууллагад олгон ажиллаж байна.	100

ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.

2.1	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх, сурталчилах	-	E-mongolia үзүүлсэн иргэдийн тоо	4900	5000		Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-р ирсэн шилжилт хөдөлгөөний 35 хүсэлт ирүүлснээс 34 бүртгэлийг татгалзаж 1 бүртгэлийг баталгаажуулан, гадаад паспортын 9 бүртгэл, цахим үнэмлэхийн 27 хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна.	100
		-	E-business үзүүлсэн иргэдийн тоо Сурталчилсан тоо	800	850		E-business цахим системээр Хуулийн этгээдийн оноосон нэрийн 1156 хүсэлтийг хүлээн авч 129 оноосон нэрийн баталгаажуулалтыг хийж ажиллаж байна.	100
2.2	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид санал өгөх, сурталчлах	-	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилсан тоо	2	3		Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын ил тод байдлыг хангах зорилготой ХУУЛЬЧДЫН ПРО БОНО БУЮУ "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"-өөр 37 иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж 93 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, аймагт үйл ажиллагаа явуулж байгаа "ХААН", "ХАС", "ГОЛОМТ", "Төрийн банк"-ны захирал эдийн засагч нарт "Барьцааны гэрээ болон барьцаалбарт тавигдах шаардлага", "Барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлт" сэдвээр сургалт мэдээлэл өгч 35 албан хаагч хамрагдсан, Газрын харилцаа барилга хот	100

						<p>байгуулалтын газарт “Улсын комисс хүлээж авсан барилга байгууламжийн акт, газар өмчлөхөд анхаарах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж 9 албан хаагчид хууль тогтоомжийн талаар сурталчлан ажилласан. Улсын бүртгэлийн тухай багц хуулийн хэрэгжилттэй холбогдуулан фэйсбүүк пэйж хуудас болон цахим хуудсаар дамжуулан сурталчилж 2026 оны эхний хагас жилд фэйсбүүк цахим хаягт үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээл 66, цахим хуудас болох www.zavkhan.burtgel.gov.mn хаягт 35 мэдээ мэдээлэл оруулан олон нийтэд түгээн ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн хууль тогтоомж,бусад хуулийг хэлтсийн цахим вэб https://zavkhan.burtgel.gov.mn/bagts-huuli https://www.gov.mn/org/zavkhan-burtgel/legal хуудасны хууль эрх зүйн цэсэд байршуулан иргэдэд олон нийтэд сурталчлан ажиллаж байна.</p>	
		-	Боловсруулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд санал хүргүүлсэн тоо	-	3	<p>Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын газар, хэлтсээс ирүүлсэн 2 удаагийн төсөлд санал хүргүүлсэн байна. Үүнд</p> <p>1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Систем-программ хангамжийн талаарх нэгдсэн бодлогоор хангах Бодлогын зөвлөл ажиллах журам”-ын төслийг албан хаагчдаар хэлэлцүүлэн</p>	100

						<p>гарсан саналыг 2026.01.07-ны өдрийн 19/9 албан бичгээр</p> <p>2. Монголд улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны 01/65 дугаар “Тайлан ирүүлэх тухай” албан бичгийн дагуу тус байгууллагын Эрсдэлийн удирдлагын 2026 оны зорилтот түвшин, арга хэмжээний төлөвлөгөөнд оруулах саналыг 2026.01.26-ны өдөр ts.urtnasan@burtgel.gov.mn хаягаар саналыг хүргүүлэн ажиллаж байна.</p>	
2.3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх.	-	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	11	13	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт эрх нээлгэх хүсэлт хүргүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/77 дугаар тушаалаар Алдархаан, Ургамал сумдын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх нээгдсэн. Эрх нээгдсэн Асгат, Баянтэс, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Тосонцэнгэл, Сонгино, Их-Уул, Тэлмэн, Тэс, Нөмрөг, Сантмаргаз сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 742 үйлчилгээ, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 94 иргэн аж ахуй нэгжид тус тус үзүүлсэн байна.	100
2.4	Иргэний андгай өргөх ёслол зохион байгуулах.	-	Арга хэмжээний тоо	1	1	Тус арга хэмжээг Улс тунхагласны баярын өдөр буюу 2026 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулахаар Улиастай сумын таван сургуулийн 16 насанд хүрч байгаа сурагчид, нийгмийн ажилтнуудтай хамтран Гэр бүл хүүхэд залуучуудын	50

							хөгжлийн газрын их танхимд зохион байгуулагдахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
ЗОРИЛТ 3. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАНА.								
3.1	Аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх.	-	Зөвлөмж, акт албан шаардлагын биелэлтийн хувь.	100	100		Аудитын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулалтаар улсын бүртгэлийн хэлтэст хандсан зөвлөмж, албан шаардлага аваагүй байна. Байгууллагын дотоод үйл ажиллагаа, санхүүгийн сахилга батыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэвийн хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх хяналтыг тавьж ажиллаж байна.	100
3.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих.	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь	99.8	99.9		Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс сар бүрийн мэдээллүүдийг дараа сарын 8-ны өдрийн дотор нээлттэй мэдээлж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар байршуулах ёстой мэдээллийг 100 хувь байршуулан ажиллаж байна.	100
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	171	171		Шилэн дансны нэгдсэн систем info.shilendans.gov.mn сайтад эхний хагас жилд 87 мэдээлэл оруулахыг 100 хувь хугацаанд нь үнэн зөв байршуулж 1 дүгээр улирлын тайланг хугацаанд нь илгээн ажиллаж байна.	
3.3	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100		Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2026.01.02-ны өдрөөс хойш хийгдсэн нийт бүртгэлээс иргэний улсын бүртгэлийн 2894	100

	замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах, архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих.						бүртгэл бүртгэгдсэнээс 228 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2493 бүртгэл бүртгэгдсэнээс 171 бүртгэлд, хуулийн этгээдийн 546 бүртгэл бүртгэгдсэнээс 30 бүртгэлд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийж иргэний 3, эд хөрөнгийн 5, хуулийн этгээдийн 1 бүртгэлийн нийт 9 зөрчлийг илрүүлэн зөрчлийг арилгах, хяналтын улсын байцаагчийн зөрчлийн тэмдэглэл, мэдэгдлийг хүргүүлэн зөрчлийг арилган цаашид тухайн зөрчлийг давтан гаргахгүй байхыг нийт улсын бүртгэгч нарт үүрэг болгон ажиллаж байна., Мөн Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй 55 иргэн, хуулийн этгээдэд зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авч ажиллаж байна.	
ЗОРИЛТ 4. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.								
4.1	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, бүртгэх	-	Бүртгэгдсэн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчдийн тооны өсөлтийн хувь	100	100		Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд бүртгэлтэй хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулж бүртгэлээ хийлгэх шаардлагатай 470 хуулийн этгээдийн жагсаалтыг гарган тэдгээрийн удирдлага, холбогдох хүмүүстэй	100

						<p>холбоо тогтоож, мэргэжлийн зөвлөгөө мэдээлэл өглөө. Өнөөдрийн байдлаар дээрх хуулийн этгээдүүдийг эцсийн өмчлөгчийн бүртгэлд шат дараатайгаар хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд тус хэлтэст шинээр бүртгүүлсэн 75 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг санд үүсгэж, бүтэц, хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх удирдлагад нь өөрчлөлт орсон 174 хуулийн этгээдийн ашиг хүртэгчийн мэдээллийг улсын бүртгэлийн нэгдсэн санд тухай бүр шинэчлэн бүртгэв. Мөн бүртгэлийн ил тод, үнэн зөв байдлыг хангах зорилгоор иргэд, аж ахуйн нэгжүүдэд цахимаар болон танхимаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.</p>	
4.2	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	-	<p>Албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо</p>	8	10	<p>Хэлтсийн ажилтан, албан хаагчдад “Авлигын эсрэг хууль”, “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг “Авлигын гэмт хэргийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Завхан аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн дарга С.Оюунтунгалаг, шүүгчийн туслах О.Түвшинжаргал, Д.Бямбабаяр нар 2 цагийн сургалтыг зохион байгуулж хэлтсийн албан ёсны пэйж хуудсанд байршуулан сурталчлан ажиллав.</p>	100

						Хэлтсийн авлигын эсрэг 2026 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
4.3	Үйлчилгээний зааланд тусгай хэрэгцээт иргэнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээнд сонсголын бэрхшээлтэй иргэн гэх таних тэмдэг болон “Тусламжийн хонх”-ыг байршуулах.	-	Таних тэмдгийг нэмж байршуулсан үйлчилгээний заалны тоо	1	2	Улсын бүртгэлийн үйлчилгээний зааланд тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор 2025 оноос сонсголын бэрхшээлтэй болон харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан таних тэмдэг, тэмдэглэгээ, брайл цагаан толгойг байршуулж, үйлчилгээний цонхнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эх, ахмад настанд дараалал харгалзахгүй үйлчлэх зурагт тэмдэглэгээ нааж үйлчилгээ авах авах иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Тусламжийн хонх”-ыг үйлчлүүлэгчид хялбар харагдах, ашиглах боломжтой хэсэгт нэмж байршуулан ашиглалтад оруулан 11 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.	100
4.4	Үйлчилгээний зааланд тэргэнцэртэй иргэн саадгүй нэвтрэх нөхцлийг бүрдүүлэх.	-	Нэвтрэх боломжийг бүрдүүлсэн үйлчилгээний заалны тоо	0	1	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж олгох хүрээнд хэлтсийн үйлчилгээний заал, гадна болон дотор орчныг засаж сайжруулах, саадгүй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.	50
4.5	Тусгай хэрэгцээт иргэдэд болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор зөөврийн тоног төхөөрөмжөөр	-	Үзүүлсэн үйлчилгээний тоо	122	200	Хэлтсийн байранд өөрийн биеэр ирэх боломжгүй, тусгай хэрэгцээт нийт 4 иргэний гэрт нь очиж улсын бүртгэлийн (иргэний үнэмлэх сунгалт, шилжилт хөдөлгөөний бүртгэл, тоон гарын үсэг) үйлчилгээг үзүүлж, Завхан аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүмүүжиж байгаа 4	100

	явуулын үйлчилгээ үзүүлэх					хүмүүжигчид иргэний үнэмлэхийн хугацаа дууссан нэг иргэний 25 насны сунгалтыг хийж 3 иргэнд иргэний цахим үнэмлэх дээр тоон гарын үсэг олгож, Тэс суманд “Монгол цэргийн өдөр”-ийг угтан зохион байгуулсан Завхан аймаг дахь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын Марш-тактикийн аварга шалгаруулах тэмцээний нээлтийн арга хэмжээний үеэр Арц суурь боомтод үүрэг гүйцэтгэж байгаа иргэний үнэмлэхийн хугацаа дууссан 3 алба хаагчийн бүртгэлийг хийж ажилласан байна.	
ЗОРИЛТ 5.ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
5.1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэх болон ажлын байрны сургалтын төлөвлөгөө” /2026-2029/ - ний дагуу зохион байгуулж байгаа сургалтад тухай бүр хамрагдан ажиллаж байна. Үүнд 1. 2026.01.14-16-ний өдөр аймаг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Захиргааны ахлах мэргэжилтний албан тушаалд томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалтад 2. 2026.03.12,13-ны өдөр “Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны 2026 оны нэгдсэн сургалт зөвлөгөөнд” 3. Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт,	100

						<p>хяналт шинжилгээ, үнэлгээ сургалтад цахимаар хэлтсийн 33 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.</p> <p>4. 2026.02.05 Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын мэргэжилтэн Б.Алтанцэцэг “Лавлагаа олгоход анхаарах асуудал”</p> <p>5. 2026.02.28 УБЕГ, Авлигатай тэмцэх газар нийслэлийн прокурорын газрын хамтарсан “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”, “ Авлигын гэмт хэрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудал”</p> <p>6. 2026.04.04 Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн архивын газрын дарга бөгөөд ёс зүйн дэд хорооны дарга С.Оюунгэрэл болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Н.Анхбаяр нарыг Завхан аймагт ажиллах хугацаанд “Ёс зүй болон ёс зүйн дэд хорооны бүтэц орон тоо, үйл ажиллагааны тайлан”, “хяналтын байцаагчийн хяналт болон зөрчлийн арга хэмжээ”</p>	
5.2	Байгууллагын 2026 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Дотоод сургалтын төлөвлөгөөг УБЕГ-н даргын 2026.05.05-ны өдрийн А/94 дугаар тушаал “Сургалтын хөтөлбөр батлах тухай”, “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр 2026-2029”-ийн сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсийн дотоод сургалтын төлөвлөгөөг	

						<p>боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар дотооддоо зохион байгуулсан сургалтад:</p> <p>7. 2026.01.30 Завхан аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газраас “Авлигын эсрэг хууль”, “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг “Авлигын гэмт хэрэг”-ийн талаар</p> <p>8. 2026.02.26 аймгийн цагдаагийн газраас “Залилах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал төрөл хэлбэр, урьдчилан сэргийлэх зөвлөмж” сургалт</p> <p>9. Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын Газраас “Хүүхэд-хайр-ирээдүй” сургалт</p> <p>10. ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга цагдаагийн дэд хурандаа Д.Будзаан “Хүүхдийн эрх ба хууль”</p> <p>11. 2026.04.23 аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн нөхцөл байдал”,</p>
--	--	--	--	--	--	---

						<p>“Оффис ажлын байрны аюулгүй ажиллагаа”</p> <p>12. 2026.04.29 Аймгийн эрүүл мэндийн газар, хүүхдийн байгууллагын хамтарсан “Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Эрүүл зөв зохистой хооллоо”</p> <p>13. Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим Вебинар мэдээллийн цагийн хөтөлбөрийн Пүрэв гаргийн сургалтад тогтмол хамрагдаж байна</p> <p>14. Иргэн, Хуулийн этгээд, эд хөрөнгийн Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч нар долоо хоног бүрийн Лхагва гарагт улсын бүртгэгч нарт хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бүртгэл хийхэд анхаарах асуудлаарх сургалтыг хийж ажиллаж байна.</p>	
5.3	Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд нийт албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан тоо	40	44	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Тус арга хэмжээний эхний ээлжид хэлтсийн нийт 42 албан хаагчаас 20 ажилтныг Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран баталсан хуваарийн дагуу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд амжилттай хамруулж үлдсэн 24 албан хаагчийг дараагийн ээлжийн хуваарийн дагуу тус үзлэг,	

						шинжилгээнд хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам шинэчлэн батлагдаж хувийн хэргийн бүрдэлд 2.1.11 дэх заалт Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт нэмэгдсэн тул албан хаагчдыг аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмчийн үзлэг оношилгоонд нэмэлтээр 20 албан хаагчийг хамруулан дүгнэлт авч үлдсэн албан хаагчдыг хамруулахаар ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	---	--

Төлөвлөгөөг үнэлсэн:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

..... /Д.ДАВААНЯМ/
(гарын үсэг) (огноо)

Тэмдэг

.....

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХУУЛЬ ЗҮЙ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)

Нэгжийн дарга

..... /Э.ГАНБАТ/
(гарын үсэг) (огноо)

Тайлагнасан:

ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)

Нэгжийн дарга

..... /Ж.СҮХБААТАР/
(гарын үсэг) (огноо)

.....